



# ГАДААД ЭДИЙН ЗАСАГТ ГАРЧ БУЙ ӨӨРЧЛӨЛТИЙН ТОЙМ

---

2024 оны 04 сарын 05-ны байдлаар

---

## ТОВЧ АГУУЛГА

- БНХАУ-ын үл хөдлөх хөрөнгийн салбарын том компаниудын нэг болох Vanke хөрвөх чадварын хямралд оров.
- Зэс, алт, газрын тосны үнэ оны эхнээс 10 гаруй хувиар нэмэгдээд байна. Харин коксжих нүүрс, төмрийн хүдэрийн үнэ энэ хугацаанд 30 орчим хувиар буурав.

**1 Vanke компанийн санхүүгийн хүндрэл**

БНХАУ-ын үл хөдлөх хөрөнгийн салбарын тэргүүлэгч компаниудын нэг болох 40 жилийн түүхт Vanke компани санхүүгийн хүндрэлд ороод байна. Тодруулбал, БНХАУ-д өрнөж буй үл хөдлөхийн салбарын хямралын улмаас тус компанийн ашгийн хэмжээ 2023 онд 46 хувиар буурчээ. Түүнчлэн он гарснаас хойш борлуулалтын хэмжээ үргэлжлэн унаж, 2-р сард өмнөх оны мөн үеэс 53 хувиар буурч, хөрвөх чадварын хямрал нүүрлээд байна. Улмаар энэ оны 3-р сард тус компанийн Moody’s болон Fitch-н үнэлгээ “junk (Ba1)” ангилалд орсон нь дэлхий нийтээр тус компанид анхаарлаа хандуулахад хүргэв.



Эх сурвалж: Блүүмберг

Шэньжэнь болон Хонг Конгийн хөрөнгийн биржид давхар бүртгэлтэй тус компанийн хувьцааны үнэ 4-р сарын эхээр түүхэн доод түвшинд хүрч буурав. Vanke компанийн хувьцааны эзэмшлийг харвал хамгийн том буюу 27.2 хувь нь БНХАУ-ын Шэньжэнь мужийн засаг захиргаа эзэмшдэг Shenzhen Metro Group Co.,Ltd хэмээх төрийн өмчит компанид хамааралтай юм. Vanke компанийн 2024 оны 3-р сарын 29-нд хийсэн жилийн тайлангийн хурлын үеэр дараагийн 2 жилд өрийн хэмжээгээ 14 тэрбум орчим ам.доллаар бууруулахаа мэдэгдлээ. Үүний тулд үл хөдлөх салбараас бусад салбарын бизнесүүдээс олох орлогоо нэмэгдүүлэхээр ажиллаж байна. Мөн түүхэндээ анх удаа ногдол ашиг тараахгүй байхаар шийдвэрлэсэн байна.



**2 Түүхий эдийн үнэд гарсан өөрчлөлтийн тойм**

Дараах хүснэгтэд манай улсын экспортын гол түүхий эдүүдийн үнэ хэрхэн өөрчлөгдөж байгааг 2024 оны 04-р сарын 04-ний өдрийн байдлаар харуулж, өөрчлөлтийн гол шалтгааныг тайлбарлалаа.

**Хүснэгт 1. Экспортын гол нэрийн түүхий эдийн үнийн өөрчлөлт**

Түүхий эдийн төрөл	Үнэ	Өөрчлөлт, %			
		7 хоног	Сар	оны эхнээс	жил
Зэс	<b>9359 \$/тн</b>	<b>+5.8</b>	<b>+9.6</b>	<b>+10.2</b>	<b>+7.0</b>
	<p>Өмнөх 4 сарын турш зэсийн үнэ тонн тутамдаа 8’500-8’600 ам.долларын орчимд хэлбэлзэж байсан бол 3 сараас эхлэн өсөж улмаар 4-р сарын эхний 7 хоногт 9’000 ам.доллар/тн-ыг давав.</p> <p>Нэг талаас БНХАУ-ын боловсруулах салбарын PMI индекс нэмэгдэж, экспорт сэргэсэн болон тус улсын хэрэглээний үнэ эргэн өсөж эхэлсэн зэрэг нь цаашид зэсийн эрэлт тогтвортой байх дохиог өгч байна.</p> <p>Нөгөө талаас зэсийн баяжмалын хүрэлцээ бага байснаас шалтгаалж БНХАУ-ын зэс хайлуулагчдын дунд үнийн өрсөлдөөн бий болж, улмаар зэс хайлуулагчдын орлого сүүлийн 10 жилийн доод түвшинд хүрч буурав. Үүнээс шалтгаалж энэ оны нийт хайлуулах зэсийн хэмжээгээ 10 хүртэл хувиар танах талаар тус улсын 10 гаруй томоохон зэс хайлуулагчид хэлэлцээд байна. Хэдийгээр албан ёсны мэдээ гараагүй байгаа ч дээрх мэдээлэл цаашид хайлуулсан зэсийн нийлүүлэлт багасах хүлээлтийг зах зээлд бий болгож, зэсийн үнэ ийнхүү өсөөд байна.</p>				
Төмрийн хүдэр	<b>97.2 \$/тн</b>	<b>+0.9</b>	<b>-13.1</b>	<b>-28.5</b>	<b>-18.7</b>
	<p>БНХАУ-ын гангийн үйлдвэрүүдийн ашиг буурснаас шалтгаалж зарим үйлдвэрүүд үйл ажиллагаа явуулахгүй байна. Түүнчлэн, БНХАУ-ын эрх баригчид энэ оны 3-р сараас эхлэн тодорхой бүс нутгуудад байгаль орчны бохирдолтой холбоотой хязгаарлалтууд тогтоосон нь тэдгээр бүс нутгийн гангийн үйлдвэрлэлд сөрөг нөлөөтэй байв. Харин Австрали, Бразил зэрэг томоохон улсуудаас БНХАУ-д их хэмжээний төмрийн хүдэр нийлүүлсэн нь томоохон боомтууд дахь төмрийн хүдрийн нөөцийг нэмэгдүүлжээ. Улмаар төмрийн хүдрийн эрэлт багасч, үнэ буураад байна.</p>				
Алт	<b>2291 \$/унци</b>	<b>+2.7</b>	<b>+9.1</b>	<b>+11.3</b>	<b>+13.4</b>
	<p>ОХУ-Украин, Ойрх Дорнодод өрнөж буй мөргөлдөөн үргэлжилж, улмаар геополитикийн болоод эдийн засгийн тодорхой бус байдал өндөр хэвээр байгаа нь алтанд хөрөнгө оруулах сонирхлыг өдөөсөөр байна. Зарим эх сурвалжийн мэдээлснээр БНХАУ-ын хөрөнгө оруулагчид алтанд ихээр хөрөнгө оруулж, үнэ өсөхөд нөлөөлж байна. Учир нь тус улсад үл хөдлөх салбарын хямрал үргэлжлэхээс гадна хөрөнгийн зах нь ч сайнгүй байгаа юм. Үүнээс гадна зах зээлд Холбооны нөөцийн банк 2024 оны 6-р сард бодлогын хүүгээ бууруулах хүлээлт давамгайлж, алтанд хөрөнгө оруулагчид нэмэгдсээр байна. Эдгээр хүчин зүйлсийн нөлөөгөөр алтны үнэ түүхэнд өндөр түвшинд хүрч өслөө.</p>				
Газрын тос	<b>90.7 \$/бар</b>	<b>+5.3</b>	<b>+9.5</b>	<b>+17.7</b>	<b>+6.7</b>



<p><b>(Брент)</b></p>	<p>Газрын тосны үнэ 2024 оны эхнээс 18 орчим хувиар нэмэгдлээ.</p> <p>Энэ оны 3-р сард Украины талаас ОХУ дахь газрын тос боловсруулах үйлдвэрүүд рүү дроны дайралт хийснээр газрын тосны үнэ өсөхөд нөлөөлөв. Үүнээс гадна 4-р сарын 1-ний өдөр Израилын агаарын хүчнийхэн Сирийн нийслэл Дамаск хотод байрлах Ираны элчин сайдын яам руу довтолж, үүний улмаас Ираны цэргийн удирдах түвшний 2 албан тушаалтан зэрэг нийт 16 хүний амь үрэгдлээ. Ираны талаас энэхүү довтолгооны хариуг барихаа мэдэгдээд буй. Ийнхүү газрын тосны томоохон нийлүүлэгч Иран улсын Ойрх-Дорнодод өрнөж буй мөргөлдөөнд оролцох оролцоо нэмэгдсэн нь газрын тосны үнэ өсөх эрсдлийг нэмэгдүүлээд байна.</p> <p>Өмнөх саруудад АНУ-ын газрын тосны нийлүүлэлт сайн байсан хэдий ч хүйтэн цаг агаарын улмаас 1-р сараас хойш буураад байна. Урин цаг ирэхээр тус улсын газрын тосны нийлүүлэлт эргэн нэмэгдэх ч улс орнуудын эдийн засгийн идэвхжил нэмэгдэж байгаа нь илүү их хэмжээний газрын тосны эрэлтийг бий болгож болзошгүй байна.</p>				
<p><b>Коксжих нүүрс /СКС<sup>1</sup>/</b></p>	<p><b>192 \$/тн</b></p>	<p><b>-3.1</b></p>	<p><b>-19.0</b></p>	<p><b>-30.4</b></p>	<p><b>-28.7</b></p>
<p>БНХАУ-ын гангийн үйлдвэрлэл муу байгаа нь нүүрсний эрэлтэд сөргөөр нөлөөлж, улмаар үнэ буурсаар байна. Уурхайнууд нүүрсээ хангалттай зарж чадахгүй байгаагаас агуулахын үлдэгдэл нөөц ихэсжээ. Түүнчлэн, БНХАУ-ын коксжих нүүрсний импорт эхний 2 сард жилийн 36.5 хувиар нэмэгдээд байна.</p>					

**Ашигласан эх сурвалжийн жагсаалт:**

- Financial times
- Bloomberg terminal
- Sxcoal
- Reuters
- <https://www.ft.com/content/4c7d569f-f2b4-41fe-9e1b-d140f8744c20>
- <https://www.ft.com/content/a3c48250-e428-4c48-a304-7d61531ed444>
- <https://www.reuters.com/markets/commodities/oil-prices-lost-ground-mideast-geopolitical-tension-eases-2024-04-07/>
- <https://www.reuters.com/world/europe/europes-restless-farmers-are-forcing-policymakers-act-2024-04-03/>
- <https://edition.cnn.com/2024/03/12/business/china-moodys-downgrade-vanke-junk-intl-hnk/index.html>
- <https://www.globaltimes.cn/page/202404/1310129.shtml>
- <https://www.reuters.com/article/idUSKBN19023Q/>

<sup>1</sup> БНХАУ-ын зах зээлийн коксжих нүүрсний дундаж үнэ